МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 24 өдөр Дугаар А/538 Мөрөн сум

Инженерийн шугам сүлжээний ажлыг
ашиглалтад оруулах комисс
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2. 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Мөрөн суманд баригдсан Инженерийн шугам сүлжээний ажлыг (4 дүгээр багийн 8, 9, 19, 20 дугаар гудамж, 5 дугаар багийн 7, 8, 9 дүгээр гудамжны айл өрхүүдийг бохир усны төвлөрсөн шугамд холбох, 5 дугаар багийн 9 дүгээр гудамжны айл өрхүүдийг цэвэр усны төвлөрсөн шугамд холбох) хүлээн авч ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:
Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:
Х.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)
Р.Элбэг-Очир (Мөрөн сумын Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
С.Мөнх-Эрдэнэ (Мөрөн хот тохижилт үйлчилгээний төвийн захирал)
М.Оюунчимэг (Мөрөн сумын 4 дүгээр багийн Засаг дарга)
Ц.Хуншагай (Мөрөн сумын 5 дугаар багийн Засаг дарга)
Ш.Баасанпүрэв (Мөрөн сумын архитектор)
Д.Мягмарсүрэн (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга техник хяналтын улсын байцаагч)
Ж.Жавзанпагма (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)
Л.Бямбасүрэн (Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, хошууч)

Захирамж-2023

6712011807

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:
Д.Хажидсүрэн ("Урбан деволопмент консалтинг" ХХК-ийн инженер)
Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:
Р.Амарсайхан ("Цагаан зуун" ХХК-ийн захирал)
Л.Нямдорж (Цагаан зуун" ХХК-ийн ерөнхий инженер)
Ашиглагч байгууллагын төлөөлөл:
Д.Сүхээ (Хөвсгөл Ус суваг ХХК-ийн ерөнхий инженер)
Комиссын нарийн бичгийн дарга:
Д.Нямбат (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. Инженерийн шугам сүлжээний ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээлж ажиллахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Инженерийн шугам сүлжээний ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Д.Нямбат) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ М.ХУЯГБААТАР